



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/121

Чингис хот

┌ Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын Булаг багт Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лабораторийн шинжилгээний дүнгээр Адууны ям өвчин оношлогдсон бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/109 тоот захирамжийн хүрээнд холбогдох зааврын дагуу арга хэмжээг авч ажиллаж, дахин өвчлөл илрээгүй тул 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Тухайн суурьт эцсийн халдваргүйтгэлийг хийж ажиллахыг “Өндөрбилгэх” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Т.Сансарбаатар)-д даалгасугай.

3. Мал амьтны халдварт Адууны ям өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Д.Сандагдорж)-д даалгасугай.

4. Хязгаарлалтын дэглэмийг цуцалсантай холбогдуулан Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР